



74

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 1137

Шивээговь сум

Ажил зохион байгуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 28 дугаар зүйлийн 28.7.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Шивээговь сумын Онцгой комиссын 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэр, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 04 дүгээр хуралдааны 08 дугаар “Сумын 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд сумын Цагдаагийн хэсгийн бие бүрэлдэхүүнийг дайчлан сураггүй алга болсон иргэнийг эрэн хайх, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах ажиллагаанд шаардлагатай шатахууны зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Эрэн хайх, аврах ажиллагаанд шаардлагатай шатахууны зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3. Тус ажлыг чанартай зохион байгуулж, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Бадамханд), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

